

Golomt Capital[®]

ДЭЛХИЙН

**ЗАХ ЗЭЭЛИЙН ДОЛОО
ХОНОГИЙН ТОЙМ**

2026.07.06

Хөрөнгийн зах зээлийн онцлох мэдээ

ТОВЧ

- SpaceX компани NASDAQ-100 индекст багтсанаар эрэлт нэмэгдэнэ.
- АНУ-ын хөдөлмөрийн зах зээлийн тайлан зах зээлд 2 өөр дохиог өглөө.
- NASDAQ:ASTS 75%-ийн өсөлтийн боломж бий.
- БНХАУ-ын технологийн компаниудад хөрөнгө оруулах тохиромжтой цаг ирлээ.
- Хятадын хагас дамжуулагчийн салбар тэр дундаа Hua Hong компанийн хувьцаа анхаарлын төвд хэвээр байна.
- Эхний хагас жилийн санхүүгийн тайлан танилцуулах улирал эхэллээ.



S&P 500 индексийн 2026 оны таамаглал

Capital Economics	8,000
Deutsche Bank	8,000
Wells Fargo	7,800
Morgan Stanley	7,800
Goldman Sachs	7,750
RBC	7,750
JPMorgan	7,500
HSBC	7,500
UBS	7,500
Barclays	7,400
Bank of America	7,100
Дундаж	7,645





АНУ-ын зах зээлийн онцлох мэдээ 2026.06.29-07.05

АНУ-ын зах зээлд тусгаар тогтнолын баярын амралттай холбоотой харьцангуй тайван долоо хоног болж өндөрлөлөө. Мөн эрүүл мэнд, харилцаа холбоо болон software салбарын хувьцаанууд илүү өндөр хувийн өсөлттэй байлаа. Үүнээс гадна АНУ-ын 6-р сарын ажилгүйдлийн түвшингийн тоо мэдээ гарсан нь олны анхаарлын сэдэв болов.

SPACEХ NASDAQ-100 ИНДЕКСТ БАГТСАНААР ЭРЭЛТ БИЙ БОЛНО

Элон Маскийн үүсгэн байгуулсан SpaceX компани IPO хийснээсээ хойш ердөө нэг сарын дотор Nasdaq-100 индексэд багтах эрхээ авч, тус индексийн түүхэн дэх хамгийн хурдан бүртгэгдсэн компаниудын нэг болох гэж байна. Nasdaq биржийн мэдээлснээр, шаардлагуудыг бүрэн хангаж дуусвал SpaceX-ийн хувьцаа 7-р сарын 7-ны өдрийн арилжаанаас албан ёсоор Nasdaq-100 индексийн бүрэлдэхүүнд орно.



Энэхүү өөрчлөлт нь SpaceX-ийн хувьцаанд шинэ худалдан авалтын томоохон урсгал бий болгох төлөвтэй байна. Учир нь 800 тэрбум ам.доллараас давсан хөрөнгийг удирддаг Nasdaq-100 индексийг дагадаг ETF болон индексийн сангууд шинэ бүрэлдэхүүнээ даган SpaceX-ийн хувьцааг зайлшгүй худалдан авах шаардлагатай болно.

ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ТАЙЛАН ЗАХ ЗЭЭЛД 2 ӨӨР ДОХИО ӨГӨВ.

Сөрөг тал: 6-р сард ердөө 57 мянган ажлын байр шинээр бий болсон нь хүлээлтээс хавьгүй доогуур гарч, мөн өмнөх саруудын үзүүлэлтийг бууруулан шинэчилсэн нь АНУ-ын хөдөлмөрийн зах зээл саарч эхэлж байгааг харууллаа.

Эерэг тал: Ажилгүйдлийн түвшин 4.2% болж бага зэрэг буурсан ч зах зээл илүүтэйгээр ажлын байрны өсөлт сул байгааг анхаарсан. Үүний улмаас хөрөнгө оруулагчид Холбооны Нөөцийн Сан (Fed) эдийн засгийг дэмжихийн тулд бодлогын хүүгээ цаашид өсгөх шаардлага багасна гэж үзэж эхэлсэн.

Ажлын байрны өсөлт сул гарсан нь эдийн засагт сөрөг дохио байсан ч Fed мөнгөний бодлогоо илүү зөөлрүүлэх магадлал нэмэгдсэн гэсэн хүлээлт үүсгэснээр хөрөнгийн зах зээл үүнийг эерэгээр хүлээн авсан байна.



АНУ-ын хувьцааны техник шинжилгээ 2026.06.29-07.05

NASDAQ: ASTS 75%-ИЙН ӨСӨЛТИЙН БОЛОМЖ БИЙ - ЗОРИЛТ: 147\$



AST SpaceMobile компанийн хувьцаа 134\$ хүрч уг ханшнаасаа 52 орчим хувиар унасан билээ. Тэгвэл 63.47\$ ханш дээр маш цэвэрхэн дэмжлэг авч улмаар өсөлтийн чиглэл рүү шилжсэн харагдаж байна. Яг одоогийн байгаа ханш болох 85.62\$ хүчтэй ROC бүсийн дээр байгаа учраас өсөлт үргэлжлэх боломж харагдаж байна.

NYSE: MSFT 40%-ИЙН ӨСӨЛТИЙН БОЛОМЖ БИЙ – ДУНД ХУГАЦААНД





Хөрөнгийн зах зээлийн онцлох мэдээ 2026.06.29–07.05

Хятадын хөрөнгийн зах зээл өнгөрсөн долоо хоногт холимог хөдөлгөөнтэй байлаа. Хүлээлтээс сайн гарсан үйлдвэрлэлийн үзүүлэлт болон Хятадын Ардын банк (PBOC)-ны богино хугацааны хөрвөх чадварыг дэмжих арга хэмжээ зах зээлийн итгэлийг сайжруулсан ч дэлхий даяарх технологийн хувьцааны уналтын нөлөөгөөр хагас дамжуулагч болон AI-тэй холбоотой хувьцаанууд хүчтэй дарамтад оржээ.

ХЯТАДЫН ЧИП ЭКСПОРТЫН ГОЛ ЗАНГИЛАА БОЛЖ БҮЙ ХОНГКОНГ

Хятадын хагас дамжуулагчийн экспорт тавдугаар сард шинэ дээд түвшинд хүрч, зөвхөн Хонконг руу хийсэн нийлүүлэлт 15 тэрбум ам.долларт хүрлээ. Энэ нь 2025 оны эхэн үеэс хойш 200 гаруй хувиар өссөн үзүүлэлт юм. Ингэснээр тавдугаар сард Хятадын нийт хагас дамжуулагчийн экспортын 43% нь Хонконгоор дамжжээ.


Энэхүү өсөлт нь Хонконг зөвхөн эцсийн хэрэглэгч биш, харин Хятадын чипийн худалдаа, экспортын хамгийн том логистикийн төв болж байгааг харуулж байна. Мөн АНУ-ын экспортын хязгаарлалт, дэлхийн нийлүүлэлтийн сүлжээний өөрчлөлтийн үед Хятад бүс нутгийн худалдааны урсгалаа Хонконгоор төвлөрүүлэн зохион байгуулж байгааг илтгэж байна.

БНХАУ-ЫН ТЕХНОЛОГИЙН КОМПАНИУДАД ХӨРӨНГӨ ОРУУЛАХ ЦАГ НЬ ИРЖЭЭ

АНУ, БНХАУ-ын технологийн өрсөлдөөн шинэ шатанд шилжиж, одоо зөвхөн дотоодын зах зээл бус дэлхийн хэрэглэгчид, дэд бүтэц, технологийн экосистемийг хэн удирдах вэ гэсэн өрсөлдөөн болон өргөжиж байна. Хятадын компаниуд хиймэл оюун ухаан, дата төв, үүлэн тооцоолол зэрэг салбарт олон улсын зах зээлд эрчимтэй тэлж байгаа бол АНУ ч холбоотон орнуудтайгаа хамтран технологийн нөлөөгөө хадгалах бодлогоо улам эрчимжүүлж байна.

Мөн Alibaba болон ByteDance компаниуд Азийн бүсэд дата төвүүдээ эрчимтэй нэмэгдүүлж байгаа бол Amazon, Google, Microsoft, Oracle зэрэг АНУ-ын технологийн аваргууд мөн адил бүс нутагт хөрөнгө оруулалтаа нэмэгдүүлж байна. Мөн 2030 он гэхэд дэлхийн дата төвийн эрэлтийн 34 орчим хувийг Ази, Номхон далайн бүс бүрдүүлэх төлөвтэй байна.

HKEX:1347 HUA HONG GRACE SEMICONDUCTOR



Хүснэгт 1: Өнгөрсөн долоо хоногт тайлангаа зарласан компаниуд

E EARNINGS WHISPERS		Most Anticipated Earnings Releases								
		for the week beginning June 29, 2026								
Monday		Tuesday		Wednesday		Thursday		Friday		
Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open		
	 AeroVironment CNXC CONCENTRIX		 NIKE STZ Constellation Brands PRGS Progress		 General Mills FACTSET UniFirst MSC		 FranklinCovey Bassett THE GREENBRIER COMPANIES		 LINDSAY	
http://eps.sh/cal								© 2026 Earnings Whispers		

Хүснэгт 2: Энэ долоо хоногт тайлангаа зарлах компаниуд

E EARNINGS WHISPERS		Most Anticipated Earnings Releases								
		for the week beginning July 6, 2026								
Monday		Tuesday		Wednesday		Thursday		Friday		
Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open		
			 PENGUIN SOLUTIONS PENG ENERPAC TOOL GROUP EPAC KURA KURUS SARATOGA INVESTMENT COMP. SAR		 Helen of Troy HELE Levi's LEVI AZZ AZZ		 pepsico PEP byrna BYRN Simply Good NTI NTIC		 WD-40 COMPANY WDFC SimulationsPlus SLP DELTA DAL	
http://eps.sh/cal								© 2026 Earnings Whispers		